

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 06

№Т/63

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ
ЧӨЛӨӨЛӨН, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйл, 82.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Намхайдоржийн гаргасан өөрийн хүсэлтийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн нэгдүгээр хэсэгтэй холбогдуулан Энхбаатар овогтой Сувд (РД:ЖЮ99030208)-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсугай.
3. Ажил хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулж, дараах баримт бичиг, мэдээлэл, эд хөрөнгийг бүрэн хүлээлгэн өгөхийг Г.Намхайдоржид даалгасугай. Үүнд:
 - 3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын тэмдэглэл, тогтоол, шийдвэрийн бүрдэл;
 - 3.2. ТУЗ-ийн гишүүдийн бүртгэл, мэдээллийн сан, холбоо барих мэдээлэл;
 - 3.3. Компанийн засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам, дотоод баримт бичиг;
 - 3.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын баримт бичиг, түүний дотор зарлан мэдээлэх материал, санал хураалтын дүн, шийдвэрүүд;
 - 3.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн бүртгэл, цахим болон цаасан хэлбэрийн мэдээллийн сан;
 - 3.6. Нууц болон хязгаарлагдмал мэдээлэл, тэдгээртэй холбоотой нэвтрэх эрх, хамгаалалтын зохицуулалт;
 - 3.7. Ажил үүрэг гүйцэтгэхэд ашиглаж байсан техник хэрэгсэл, программ хангамж, нэвтрэх эрх;
 - 3.8. Хэрэгжиж буй ажил, шийдвэрийн биелэлт, хүлээгдэж буй үүрэг даалгаврын жагсаалт;
 - 3.9. Бусад холбогдох баримт бичиг, эд зүйлс.
4. Ажил хүлээлцэх явцад илэрсэн зөрчил, дутагдал, дутуу баримт бичгийн талаар актад тусган тэмдэглэж хүлээлгэн өгөхийг Г.Намхайдоржид, хүлээн авахыг Э.Сувд нарт тус тус даалгасугай.
5. Шинээр томилогдож буй ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Сувдад ажил, үүргийг бүрэн хүлээн авснаас хойш Компанийн тухай хууль, компанийн дүрэм, дотоод журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Билгүүнд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БИЛГҮҮН

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 06

№Т/62

Улаанбаатар хот

ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Компанийн Дүрмийн 7.21.9 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 3.2.2, 3.2.2.1 дэх хэсэг, 3.2.3, 3.2.3.1 дэх хэсэг, 7.28 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, компанийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг алдагдуулахгүй байх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Билгүүнд дараах давхар эрхүүдийг олгосугай. Үүнд:
 - 1.1. Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
 - 1.2. Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа албан бичиг, баримт бичгийг баталгаажуулах, албажуулах, гарын үсэг зурах;
 - 1.3. Компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл байгуулах, өөрчлөх;
 - 1.4. Төрийн болон төрийн бус байгууллага, харилцагч, гуравдагч этгээдтэй харилцах, компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
 - 1.5. Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд шаардлагатай шуурхай арга хэмжээ авч, холбогдох шийдвэр гаргах;
 - 1.6. Банк, санхүүгийн байгууллагатай харилцах, данс нээх, хаах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах;
 - 1.7. Компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэр, заавар батлах.
2. Энэхүү шийдвэрийг батлагдсан өдрөөс эхлэн Компанийн Гүйцэтгэх захирал/Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох өдөр хүртэл хүчинтэйд тооцсугай.
3. Өөрт олгогдсон эрхийн хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны талаар Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг Л.Билгүүнд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудит эрсдэлийн хороо (Ч.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

